

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
3.1. Зардлын данстай холбоотой асуудал.....	8
3.2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.....	9
3.3. Шилэн данстай холбоотой асуудал .....	9
3.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөлтийн талаар:.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2. Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4. Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5. Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ  
ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ  
ШИНЭЭР БАРИХ ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ Т.БОЛОРЧУЛУУН  
ТАНАА

2020.02.21 № 06/566  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төслийн зохицуулагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Т.Болорчулуун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэх, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Мишээл-Од Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 8/2020 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зорилго нь цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг хоногт 250 000 м3 болгож нэмэгдүүлж, ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг Монгол улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой ба цэвэрлэх байгууламжаас гарах усыг хэт ягаан туяаны UV төхөөрөмжөөр халдваргүйжүүлэн Туул голд нийлүүлэх, лагаас мезофил зарчмаар биохий гарган авах замаар эрчим хүч, дулаан гаргаж өөрийн үйлдвэрлэлийн дотоод хэрэгцээний зардлыг нөхөж, улмаар эрчим хүч үйлдвэрлэдэг цэвэрлэх байгууламж болох эхлэлийг тавих явдал юм.

Монгол Улсын Засгийн газрын 2017 онд 311 тоот тогтоолоор “Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийг баталж БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох /1.0/ нэг тэрбум ам долларын зээлээс 262.7 сая ам долларыг зарцуулан 17.6 га газрыг ашиглан барихаар төлөвлөж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг 2023 онд дуусгахаар төлөвлөн гүйцэтгэгч байгууллагаар БНХАУ-ын Чайна Тисижу сивил инженеринг групп ба Бээжин констракшн инженеринг группүүдийн консорциум ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”;
- Засгийн газрын 2019 оны 5 тоот тогтоолоор “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус төслийн нэгж нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS 3.0” програм хангамж ашигладаг байна.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 782,227.2 мянган төгрөгөөс тооцон 15,644.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 15,644.5 мянган төгрөгөөр тооцсон нь төслийн үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, үйл ажиллагааны орлого, зардал, эрсдэл бага байгаатай холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь 2019 оны 7 дугаар сараас үйл ажиллагаа нь эхэлсэн ба жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 210,675.5 мянган төгрөг байна. Жилийн эцсийн байдлаар бараа материал, биет болон биет бус хөрөнгийн дүн санхүүгийн тайланд үлдэгдэлтэйгээр тусгагдсан байна.

Бараа материалын дансны 35,257.2 мянган төгрөгийн үлдэгдэл нь 2019 онд худалдан авсан хөрөнгүүд байна.

Биет хөрөнгө дансны 173,738.5 мянган төгрөг, биет бус хөрөнгө дансны 1,679.8 мянган төгрөгийн үлдэгдэл нь 2019 онд худалдан авсан 180,810.4 мянган төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмжийн элэгдэл хасагдсан дүн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,222,590.0 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталснаас 992,902.7 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, 498,312.3 мянган төгрөгийг зарцуулж 494,540.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,056.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Шинээр баригдах Төв цэвэрлэх байгууламж нь нийт 262.7 сая ам долларын хөрөнгөөр баригдахаар төлөвлөгдсөн байна. Үүний 5 хувь буюу 13.1 сая долларын хөрөнгийг Монгол Улсын Засгийн газар, 95 хувь буюу 249.6 сая ам долларыг БНХАУ-ын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Энэ 95 хувийн зээлийн хөрөнгийн зарцуулалт, байгууламжийг барих ажлын гүйцэтгэлд төслийн нэгж хэрхэн хяналт тавих талаар одоогоор тодорхойгүй байгаа учир дараагийн аудитаар гол анхаарах асуудлаар авч үзэхээр шийдвэрлэв.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 3 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Тус төслийн нэгж нь 2019 оны 6 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн учир өмнөх аудитын зөвлөмж байхгүй байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 1,056.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 15,644.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Тайлант онд зарцуулсан 1,056.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг жишиг нормоор тооцож бодоогүй, хүчингүй болсон анхан шатны маягт ашиглаж байна.

Энэ нь тайлант онд мөрдөгдөж байсан Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газрын тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчих;

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын дагуу шатахууны тооцоог үнэн зөв тооцох

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

2020 оны 1 дүгээр сараас эхлэн шинэ маягтаар тооцоог бодож байна. Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллана

### **3.2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

#### **3.2.1. Илрүүлэлт:**

Тендерийн баримтыг архивын нэгж болгон хадгалаагүй, гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг тендерийн баримт бичигт хавсаргаагүй, акт үйлдсэн эсэх нь тодорхойгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах мэдүүлэгт гарын үсэг дутуу, үнэлгээний хорооны гишүүний АЗ-ын гэрчилгээг дутуу хавсаргасан, тендерийн баримт бичигт заасан 1 шалгуур үзүүлэлтийг үнэлгээ хийхдээ орхигдуулсан зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.2.2. Эрсдэл:**

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгээгүй байх, хууль зөрчигдөх;

#### **3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Тендерийн баримтыг холбогдох хуульд заасны дагуу бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах, үнэлгээний хорооны гишүүдийн ажиллах журмыг мөрдөж ажиллах;

#### **3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж, хуулийг мөрдөж ажиллана.

### **3.3. Шилэн данстай холбоотой асуудал**

#### **3.3.1. Илрүүлэлт:**

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 3 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.3.2. Эрсдэл:**

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байх;

#### **3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

#### **3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Төслийн ажил шинээр эхэлсэнтэй холбоотой шилэн дансанд мэдээлэл байршуулах эрхийг хугацаа хоцорч авсан цаашид цаг хугацаанд нь байршуулж ажиллана.

### **3.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөлтийн талаар:**

#### **3.4.1. Илрүүлэлт:**

Тус төслийн нэгж нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дугаар зүйлд “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.4.2. Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, дүрэм, журмуудын өөрчлөлтийг тусгаагүй байх;

#### **3.4.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хууль, дүрэм журам, өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулан мөрдөж ажиллах;

#### **3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b><u>35,257,192.00</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		00.00
33	АВЛАГА		00.00
35	БАРАА МАТЕРИАЛ		35,257,192.00
354	Хангамжийн материал		35,257,192.00
35410	Бичиг хэргийн материал		1,751,600.00
35440	Түлш, шатах тослох материал		5,115,225.00
35470	Бусад хангамжийн материал		28,390,367.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>175,418,342.99</u></b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		175,418,342.99
392	Биет хөрөнгө		173,738,476.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		104,568,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		-3,627,826.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		74,518,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		-1,720,087.00
393	Биет бус хөрөнгө		1,679,866.67
39303	Бусад биет бус хөрөнгө		1,724,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		-44,133.33
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>210,675,534.99</u></b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<b><u>00.00</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>210,675,534.99</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо		210,675,534.99
512	Хуримтлагдсан үр дүн		210,675,534.99
51210	Өмнөх үеийн үр дүн		00.00
51220	Тайлант үеийн үр дүн		210,675,534.99
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>210,675,534.99</u></b>

#### 4.2. Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>00.00</b>	<b>992,902,700.00</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>00.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>00.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>992,902,700.00</b>
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>		992,902,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		992,902,700.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>782,227,165.01</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>782,227,165.01</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		287,636,731.34
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		23,227,049.23
210201	Тэтгэврийн даатгал		23,227,049.23
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		33,806,000.00
210304	Байрны түрээс		33,806,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		12,192,863.00
210401	Бичиг хэрэг		2,547,285.00
210402	Тээвэр, шатахуун		1,056,375.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,173,730.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,415,473.00
2105	<b>Нормативт зардал</b>		00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		837,050.00
210604	Урсгал засвар		837,050.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>		17,949,488.80
210701	Гадаад албан томилолт		2,649,488.80
210702	Дотоод албан томилолт		15,300,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		194,232,233.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		194,232,233.30
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		5,392,047.01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		5,392,047.01
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		494,590,433.67
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		494,590,433.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		494,590,433.67
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>210,675,534.99</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>00.00</b>	<b>210,675,534.99</b>

#### 4.3. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>00.00</b>	<b>992,902,700.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО		00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	992,902,700.00
1330	Төсвийн захирагчдаас		992,902,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		992,902,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>00.00</b>	<b>812,092,310.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		812,092,310.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	317,501,876.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		41,163,927.13
210201	Тэтгэврийн даатгал		41,163,927.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		33,806,000.00
210304	Байрны түрээс		33,806,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		15,464,480.00
210401	Бичиг хэрэг		3,876,785.00
210402	Тээвэр, шатахуун		6,171,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,173,730.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,242,365.00
2105	Нормативт зардал		00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		24,796,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		199,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		23,760,000.00
210604	Урсгал засвар		837,050.00
2107	Томилолт, зочны зардал		17,949,488.80
210701	Гадаад албан томилолт		2,649,488.80
210702	Дотоод албан томилолт		15,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		184,321,430.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		184,321,430.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	494,590,433.67
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		494,590,433.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		494,590,433.67
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>180,810,390.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		180,810,390.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-180,810,390.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		00.00

#### 4.4. Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн				
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			210,675,534.99	210,675,534.99
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>210,675,534.99</b>	<b>210,675,534.99</b>

#### 4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,222,590,000.00	498,312,266.33	724,277,733.67	40.8
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,222,590,000.00	498,312,266.33	724,277,733.67	40.8
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,222,590,000.00	498,312,266.33	724,277,733.67	40.8
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,837,900.00	41,163,927.13	4,673,972.87	89.8
Тэтгэврийн даатгал	45,837,900.00	41,163,927.13	4,673,972.87	89.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,470,000.00	33,806,000.00	664,000.00	98.1
Байрны түрээс	34,470,000.00	33,806,000.00	664,000.00	98.1
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,465,400.00	15,464,480.00	920.00	100.0
Бичиг хэрэг	2,100,000.00	3,876,785.00	-1,776,785.00	184.6
Тээвэр, шатахуун	6,171,600.00	6,171,600.00	00.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,208,800.00	2,173,730.00	1,035,070.00	67.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,985,000.00	3,242,365.00	742,635.00	81.4
<b>Нормативт зардал</b>	00.00	00.00	00.00	
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	282,503,300.00	203,882,940.00	78,620,360.00	72.2
Багаж, техник, хэрэгсэл	153,312,100.00	100,158,400.00	53,153,700.00	65.3
Тавилга	90,411,200.00	79,127,490.00	11,283,710.00	87.5
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,200,000.00	23,760,000.00	12,440,000.00	65.6
Урсгал засвар	2,580,000.00	837,050.00	1,742,950.00	32.4
<b>Томилолт, зочны зардал</b>	51,197,600.00	17,949,488.80	33,248,111.20	35.1
Гадаад албан томилолт	00.00	2,649,488.80	-2,649,488.80	
Дотоод албан томилолт	51,197,600.00	15,300,000.00	35,897,600.00	29.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	570,414,000.00	186,045,430.40	384,368,569.60	32.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	570,414,000.00	186,045,430.40	384,368,569.60	32.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	222,701,800.00	0.00	222,701,800.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	222,701,800.00	0.00	222,701,800.00	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,222,590,000.00	498,312,266.33	724,277,733.67	40.8
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,222,590,000.00	498,312,266.33	724,277,733.67	40.8
Улсын төсвөөс санхүүжих	1,222,590,000.00	498,312,266.33	724,277,733.67	40.8
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00	
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	17	9	8	52.9
Удирдах ажилтан	1	1	0	
Гүйцэтгэх ажилтан	15	7	8	52.9
Үйлчлэх ажилтан	1	1	0	



**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	2020.02.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/703/СТА-ТХН

Шалгагдсан байгууллагын нэр:	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Мянган төгрөгөөр
------------------------------	--	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд зарцуулсан 1,056.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг жишиг нормоор тооцож бодоогүй, хүчингүй болсон анхан шатны маягт ашиглаж байна.	1,056.7	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Т.Болорчулуун Х.Галсанхүү
2	Тендерийн баримт бичгийг архивын нэгж болгон хадгалаагүй, гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг тендерийн баримт бичигт хавсаргаагүй, акт үйлдсэн эсэх нь тодорхойгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах мэдүүлэгт гарын үсэг дутуу, үнэлгээний хорооны гишүүний А-3-ын гэрчилгээг дутуу хавсаргасан, тендерийн баримт бичигт заасан 1 шалгуур үзүүлэлтийг үнэлгээ хийхдээ орхигдуулсан зэрэг зөрчлүүд байна.		Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Т.Болорчулуун Х.Галсанхүү
3	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 3 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.		Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Т.Болорчулуун Х.Галсанхүү
4	Тус төсөл Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.		Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Т.Болорчулуун Х.Галсанхүү
	<b>Нийт дүн</b>	<b>1,056.7</b>			





## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.